



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/498

Булган

Төслийн багийг татан буулгах тухай

Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус “Төслийн баг” нь аймгийн мал аж ахуй, газар тариалангийн болон орон нутгийн түгээмэл тархацтай түүхий эд, байгалийн ургамлын нөөцөд түшиглэн жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт бүс, бүсээр нь төрөлжүүлэн хөгжүүлэх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах суурь судалгаануудыг хийж, анхны төсөл “Чацаргана” төслийг эхлүүлсэн зэрэг эхний шатны ажил дууссан гэж үзэж аймгийн Засаг даргын зөвлөлийн тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус “Төслийн баг”-ийг татан буулгасугай.

2. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг цаашид холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан үргэлжлүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Бат-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Орон тооны бус “Төслийн баг”-т ажилласан хоёр ажилтны үлдэгдэл цалинг бодож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/390 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ